

БАТЛАВ.
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА ~~Х.БАТЖАРГАЛ~~



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛЭЭГ ЦАХИМЖУУЛАХ ЦОГЦ ПРОГРАМ ХАНГАМЖ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛСАН ТЕНДЕРИЙН
БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: Байгууллагын үйлчилгээг цахимжуулах цогц програм хангамж
Тендерийн дугаар: ҮХГ2021/03005

УЛААНБААТАР
2021

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2021 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Тендерийн нэр: Байгууллагын үйлчилгээг цахимжуулах цогц програм хангамж

Тендерийн дугаар: ҮХГ2021/03005

Захиалагчийн нэр: Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газар

Үндэсний хөгжлийн газар нь энэхүү тендерийн баримт бичигт заасан нөхцөл, шаардлагыг хангасан тендерт оролцогчдоос “Байгууллагын үйлчилгээг цахимжуулах цогц програм хангамж” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 10.00 цагаас өмнө Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, 220 тоот хаягаар ирүүлнэ үү.

Үнийн саналыг тус нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 10:30 цагт нээнэ. Дотоодын давуу эрх тооцохгүй бөгөөд гадаадын этгээд оролцохгүй болно.

Тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр авах боломжтой тул Тендерт оролцохыг сонирхсон этгээд тендерийн баримт бичигт тусгагдсан техникийн тодорхойлолт болон холбогдох бусад мэдээллийг доорх хаягаар болон Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn цахим системээс татаж авна уу.

(Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, 220 тоот, мэргэжилтэн Д.Отгонбаатар утас:261543,99020187, [http://nda.gov.mn/](http://nda.gov.mn) цахим хаяг)

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн 2018, 2019 оны тайлан, туршлагын мэдээлэл/ болон бусад баримт бичиг
(г) Холбогдох эрх бүхий байгууллагуудад өртэй эсэхийг тодорхойлсон баримт |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн 3 [2018, 2019, 2020] жилийн санхүүгийн тайлан /2018, 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хамт/; - Ижил, төсөөтэй ажил гүйцэтгэсэн талаарх туршлагын мэдээлэл 3-аас доошгүй /гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбар/; - Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, танилцуулга; - Сонгосон програм хангамжийн үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, итгэмжлэл, техникийн тодорхойлолт, дэлгэрэнгүй танилцуулга; - Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө 2020 оны байдлаар бүрэн төлсөн тухай баримт; - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт. <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [шаардлагатай тусгай зөвшөөрлийг бичнэ.]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа: Байгууллагын хаяг: Үндэсний хөгжлийн газар, Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот Давхар болон өрөөний дугаар: 2 давхарт 220 тоот, мэргэжилтэн Д.Отгонбаатар, утас: 264315, 99020187 Огноо: 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа: Байгууллагын хаяг: Үндэсний хөгжлийн газар, Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот Давхар болон өрөөний дугаар: 3 давхар, Хурлын танхим Огноо: 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багц байхгүй</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ПРОГРАМЫН ЛИЦЕНЗИЙН ТОО, ШИРХЭГ

№	Програм хангамжийн нэр	Тоо	Бүрдэл хэсэг
1	Microsoft 365 business standart	55	Хувилбар: Microsoft 365 Business standard Desktop apps: Outlook, Word, Excel, PowerPoint, Publisher, Access Services: OneDrive, Teams, SharePoint, Exchange Лицензийн хугацаа: 365 хоног
3	Microsoft Exchange Online (plan1)	2	Хувилбар: Microsoft Exchange Лицензийн хугацаа: 365 хоног

ҮНДСЭН ШААРДЛАГА

Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Техникийн тодорхойлолт болон шаардлага	Бүрдүүлэх баримт бичиг
Microsoft компанийн албан ёсны партнер байх	Microsoft-н албан ёсны доорх шаардлагыг хангасан түнш байх. Үүнд: Cloud Productivity Small and Midmarket Cloud Solutions	Microsoft-н албан ёсны төлөөлөгчийг баталсан баримт бичиг хавсаргах
Ажлын төлөвлөгөөний дагуу лиценз сунгалтыг хийх	Нэвтрүүлэлт хийх инженерүүдийн Microsoft албан ёсны сертификатыг ирүүлэх. Үүнд: MSA түвшний сертификаттай 2 ба түүнээс дээш	Ажлын төлөвлөгөө, сертификат хавсаргах
Үндэсний хөгжлийн газрын хуучин ашиглаж байсан дата төв дээрх email-дийг backup хийн Microsoft exchange рүү шилжүүлэх	Нэвтрүүлэлт хийх инженерүүдийн Microsoft албан ёсны сертификатыг ирүүлэх. Үүнд: MSA түвшний сертификаттай 2 ба түүнээс дээш	Ажлын төлөвлөгөөг
Outlook, Sharepoint, OneDrive дээр хэрхэн датагаа менежементтэйгээр хадгалах, аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах, файлыг хэрхэн сэргээх талаар сургалт хийх	Сургалтыг практикт суурилан биечлэн болон онлайнаар бүх ажилтнуудад 1 цагийн сургалт хийх	Сургалтын агуулгыг хавсаргах
SharePoint + Flow програмаар дотоод процессыг автоматжуулах сургалт хийх	Сургалтыг практикт суурилан биечлэн болон онлайнаар бүх ажилтнуудад 1 цагийн сургалт хийх	Сургалтын агуулгыг хавсаргах
Planner програмын тусламжтайгаар Task хэрхэн үүсгэх, ажлын гүйцэтгэлийг хэрхэн хянах, тайлан татах талаар сургалт хийх	Сургалтыг практикт суурилан биечлэн болон онлайнаар бүх ажилтнуудад 1 цагийн сургалт хийх	Сургалтын агуулгыг хавсаргах
Teams програмыг ашиглан хэрхэн гадны хэрэглэгчийг урьж хамтран ажиллах, Онлайн хурлыг хэрхэн зарлах, Архив хэрхэн хийх, Эрхийн тохиргоог хэрхэн хийх, Хэрхэн зөв зохион байгуулалттайгаар Teams үүсгэн хамтран ажиллах талаар	Сургалтыг практикт суурилан биечлэн болон онлайнаар бүх ажилтнуудад 1 цагийн сургалт хийх	Сургалтын агуулгыг хавсаргах

сургалт хийх		
--------------	--	--

ДОТООД ПРОЦЕССЫГ АВТОМАТЖУУЛАХ

<p>Дотоодын ирсэн болон явсан Албан бичгийн системийг 365 программ ашиглан хөгжүүлж нэвтрүүлэн нийт хэрэглэгч нарт системийг ашиглах зааварчилгаа, гарын авлага, Видео хичээл бэлтгэх</p>	<p>Тус дотоод процессын системийг хэрхэн хөгжүүлэх талаар шийдэл боловсруулах, нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулна</p>	<p>Шийдэл, ажлын төлөвлөгөөг хавсаргах</p>
---	---	--

Нэмэлт: Microsoft 365 програмууд /PowerApps, PowerAutomate болон Sharepoint/-ыг ашиглан процесс автоматжуулалт хийж байсан туршлагатай байх. Тухайн ажлын гэрээ, дэлгэцийн зураг болон ажлын актаар баталгаажуулах.

Жич: Дээрх техникийн тодорхойлолтод заасан нэр бүхий эсхүл түүнтэй дүйцэхүйц програм хангамж байж болно.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(**Үндэсний хөгжлийн газар**)-ын дарга Х.Батжаргал танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [**санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр**] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [**тоо**] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа нэг ба түүнээс дээш жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Барааг хүлээлцэх үед нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагчийн төлөөлөл барааг ажиллуулж шалгана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт;
3) нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
2.2. Энд жагсаасан баримт бичгийг барааг хүлээлцэх үед захиалагчид өгнө. Холбогдох баримт бичгэнд гарын үсэг зурж хүлээлцэх хүртэл барааны бүрэн бүтэн, аюулгүй байдлыг нийлүүлэгч дангаараа хариуцна. Дагалдах баримт бичгийг хугацаанд нь захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Захиалагч нэхэмжлэхийг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор Гэрээний үнийн дүнгийн [100]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | 6.1. Алданги оногдуулах хувь: [нэг долоо хоногт 0,5 хувь]

Алдангийн нийт дүн: [гэрээний үнийн дүнгийн 10 хувь] |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

Үндэсний хөгжлийн газрын албан хэрэгцээнд багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

2018 оны 12 дугаар сарын
өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас **Үндэсний хөгжлийн газар** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **Үндэсний хөгжлийн газрын албан хэрэгцээнд багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг 2018 оны 12 дугаар сарын 26-нээс 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
 - Үнийн санал;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

6. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
7. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр
Утас: 263333

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]